

Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
383 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Цаг уур, орчны шинжилгээний газар

Нэгжийн нэр:

Улсын сүлжээ, уур амьсгалын
үйлчилгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Уур амьсгалын болон орон нутгийн
үйлчилгээ хариуцсан ахлах
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг, 4
дүгээр хороо, Жуулчны гудамж-5, Цаг уур,
орчны шинжилгээний газар

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цаг агаар, уур амьсгалын мэдээ, мэдээллээр хэрэглэгчид үйлчлэх арга зүй, технологийг нэвтрүүлж хэрэгжүүлэх, уур амьсгалын нөөц ашиглалт, мэдээний хэрэглээ, үр ашгийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.“Уур амьсгалын үйлчилгээ”-г Дэлхийн цаг уурын байгууллагын дэвшүүлсэн тэргүүлэх чиглэлээр нэвтрүүлэх, хэрэгжүүлэх.

2.Уур амьсгалын үйлчилгээ болон цаг агаарын мэдээгээр үйлчилгээ үзүүлэх арга зүй нэвтрүүлэх, үйлчилгээний ажилд хяналт тавих.

3.Тусгай хэрэгцээний болон уур амьсгалын мэдээний үйлчилгээ, үр ашгийг тооцох ажлыг зохион байгуулах.

4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдалд уур амьсгалын үйлчилгээ үзүүлэх ДЦУБ-ын баримт бичиг, олон улсын туршлага судлах, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулж батлуулах, нэвтрүүлэх;	Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал чиглэлээр үйлчилгээний бодлогын баримт бичиг болон зөвлөмж гарч хэрэгжүүлсэн байна.	Г
	2.Гамшгийн эрсдлийг бууруулах уур амьсгалын үйлчилгээ үзүүлэх ДЦУБ-ын баримт бичиг, зөвлөмж, олон улсын туршлага судлах, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулж батлуулах, нэвтрүүлэх;	Гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр үйлчилгээний бодлогын баримт бичиг болон зөвлөмж гарч хэрэгжүүлсэн байна.	Г
	3.Эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалтад уур амьсгалын үйлчилгээ үзүүлэх ДЦУБ-ын баримт бичиг, олон улсын туршлага судлах, бодлогын баримт бичиг болон зөвлөмжийн төсөл боловсруулж батлуулах, нэвтрүүлэх;	Эрчим хүч чиглэлээр үйлчилгээний бодлогын баримт бичиг болон зөвлөмж гарч хэрэгжүүлсэн байна.	Г
	4.Эрүүл мэндийн байгууллагад уур амьсгалын үйлчилгээ үзүүлэх ДЦУБ-ын баримт бичиг, зөвлөмж, олон улсын туршлага судлах, бодлогын баримт бичиг болон зөвлөмжийн төсөл боловсруулж батлуулах, нэвтрүүлэх;	Эрүүл мэндийн чиглэлээр үйлчилгээний бодлогын баримт бичиг болон зөвлөмж гарч хэрэгжүүлсэн байна.	



	5.Усны хэрэглээ, ашиглалтын байгууллагад уур амьсгалын үйлчилгээ үзүүлэх ДЦУБ-ын баримт бичиг, зөвлөмж, олон улсын туршлага судлах, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулж батлуулах, нэвтрүүлэх;	Усны хэрэглээ, ашиглалтын чиглэлээр үйлчилгээний бодлогын баримт бичиг болон зөвлөмж гарч хэрэгжүүлсэн байна.	Г
	6.ДЦУБ-ын Уур амьсгалын үйлчилгээний мэдээллийн системийн байгууллагын бодолгын хэрэгжилтийг хангах Үндэсний зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх;	ДЦУБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн байна.	Г
	7.ДЦУБ-ын Зүүн хойд Азийн шар шороон шуурганы мониторингийн сүлжээний Үндэсний зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх;	ДЦУБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Орон нутагт цаг агаарын мэдээгээр үйлчлэх ажлыг нэгтгэн дүгнэх болон Уур амьсгалын үйлчилгээ үзүүлэх арга зүй, технологийн төслийг боловсруулж батлуулах, арга зүйгээр хангах;	Арга зүй, технологи, батлагдан гарч хэрэгжсэн байна. Үйлчилгээний ажлыг дүгнэсэн байна.	Г
	2.Уур амьсгалын үйлчилгээг үнэлэх, үр ашгийг нь тооцох, дүгнэх ажлын төслийг боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Арга зүй, технологи, гарын авлага, журам батлагдан гарч хэрэгжсэн байна.	Г
	3.Орон нутгийн цаг агаарын мэдээний үйлчилгээнд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн зөвөлгөөгөөр хангах;	Үйлчилгээний ажилд заавар, зөвөлгөө өгсөн байна.	Г,Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Тусгай хэрэгцээний мэдээний үнэ тариф тогтоох баримт бичгийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх;	Тусгай хэрэгцээний мэдээний үнэ, тариф баталгаажиж, үр ашиг тооцсон байна.	Г
	2.Тусгай хэрэгцээний мэдээний үр ашгийг тооцох, үнэлэх ажлыг зохион байгуулах;	Тусгай хэрэгцээний мэдээний үнэ, тариф баталгаажиж, үр ашиг тооцсон байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Төрийн албаны тухай хууль холбогдох бусад хууль, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх;	Хууль, тогтоол, журам, дүрэм хэрэгжсэн байна.	Г

2.Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэж, тайлагнах;	Өгөгдсөн үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгэсэн байна.	Г
3.Байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачлагатай оролцох;	Идэвхтэй оролцсон байна.	Г
4.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний саналыг боловсруулж батлуулах, хэрэгжүүлж тайлагнах	Төлөвлөгөөт зорилтууд бүрэн биелсэн байна.	Г
5.Хугацаатай мэдээ, тайлан, судалгааг гаргаж хүргүүлэх;	Тайлан, судалгааг хугацаанд нь хүргэнэ.	Г
6.Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийн дагуу ХАСХОМ-ийг хугацаанд нь үнэн зөв мэдүүлэх;	Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн байна.	Г
7.Албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хавтас хэрэг бүрдүүлж, дараа оны 1-р улиралд багтаан хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөх;	Цаасан суурьтай болон цахим баримт бүрдүүлсэн байна.	Г
8.Иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;	Хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г
9.Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;	Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээ хангагдана.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	Цаг уур /053207/, уур амьсгал судлал /053209/.	
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд мэргэжлээрээ 4-өөс доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;

		- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бүтээлч, санаачилгатай ажиллах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - нээлттэй, шударга байх; - бусад.
	Бусад	- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- 1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох газар хэлтсүүд
- 2.Газрын харъяа байгууллагын удирдлага, нэгжийн дарга
- 3.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Ажлын хэсгийн ахлагч, газрын дэд дарга

Б.БАТТУЛГА

2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19.12.12

Дугаар: 383

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо.....2020.01.03

Дугаар:А/01

(тамга/тэмдэг)

ДАРГА

С.ЭНХТҮВШИН

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20 20 оны 01 дугаар сарын 03 -ны өдөр

